



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БУА-2022/17/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2022 он</p>	<p>Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр: Утас: 70342580 Цахим хаяг: Ankhbayard@audit.dov.mn</p> <p>Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn</p> <p>Аудитор: Б.Энхтөр Утас: 70342495 Цахим хаяг: Enkhturb@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4-15
3. Аудитын тайлан.....	15-18
3.1 Ерөнхий зүйл.....	
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	
3.4 Материаллаг байдал.....	
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	
3.8 Аудитын гол асуудал.....	
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	
4. Аудитын илрүүлэлт.....	18-19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	19



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-3259
E-mail: bulgan@audit.gov.mn

2022.02.25 № 65
танай _____ ны № _____ т

ГЭР БҮЛ, ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫН
ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГА
Т.БАЯРБАТ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

D:/bichighereg/2022A4toot

006020090

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

D:/bichighereg/2022A4/oot

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

АДБОУС Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

ТӨБЗГ Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	15,223,673.08	22,308,273.08
33	АВЛАГА	9,535,000.00	3,268,900.00
335	Бусад авлага	9,535,000.00	3,268,900.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	3,268,900.00
35	БАРАА МАТЕРИАЛ	5,688,673.08	19,039,373.08
351	Түүхий эд материал	750,000.00	6,330,700.00
35110	Тусгай зориулалттай материал	750,000.00	6,330,700.00
354	Хангамжийн материал	4,938,673.08	12,708,673.08
35420	Аж ахуйн материал	4,938,673.08	12,708,673.08
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	425,762,321.70	412,706,697.70
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	425,762,321.70	412,706,697.70
392	Биет хөрөнгө	405,185,655.06	392,296,697.70
39201	Барилга, байгууламж, орон сууц	344,617,178.39	344,617,178.39
39202	Хуримтлагдсан элэгдэл	(38,481,294.96)	(57,721,942.26)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	23,500,000.00	23,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(5,385,416.74)	(8,322,916.78)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	82,774,317.97	114,173,917.97
39206	Хуримтлагдсан элэгдэл	(34,391,019.82)	(51,114,636.08)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	46,551,219.00	46,551,219.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(15,444,328.78)	(20,831,122.54)
39217	Ном	1,445,000.00	1,445,000.00
393	Биет бус хөрөнгө	20,576,666.64	20,410,000.00
39301	Программ хангамж	500,000.00	500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(333,333.36)	(500,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	20,410,000.00	20,410,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	440,985,994.78	435,014,970.78
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	440,985,994.78	435,014,970.78
51	Засгийн газрын хувь оролцоо	440,985,994.78	435,014,970.78
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	108,611,173.00	108,611,173.00
512	Хуримтлагдсан үр дүн	167,509,357.35	161,538,333.35
51210	Өмнөх үеийн үр дүн	167,509,357.35	167,509,357.35
51220	Тайлант үеийн үр дүн	-	(5,971,024.00)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	164,865,464.43	164,865,464.43
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	440,985,994.78	435,014,970.78

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	-	356,491,900.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	31,399,600.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	31,399,600.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	31,399,600.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	31,399,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	325,092,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	122,131,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	122,131,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	139,255,300.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	139,255,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	63,705,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	63,705,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	-	362,462,924.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	362,462,924.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	357,351,508.26

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	133,625,760.00
210101	Үндсэн цалин	-	115,163,667.00
210102	Нэмэгдэл	-	18,462,093.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	18,213,602.26
210201	Тэтгэврийн даатгал	-	13,338,137.58
210202	Тэтгэмжийн даатгал	-	1,237,791.17
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	970,152.90
210204	Ажилгүйдлийн даатгал	-	242,438.27
210205	Эрүүл мэндийн даатгал	-	2,425,082.34
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	62,205,300.00
210301	Гэрэл, цахилгаан	-	2,700,208.43
210302	Түлш, халаалт	-	57,785,300.00
210303	Цэвэр, бохир ус	-	1,719,791.57
2104	Хангамж, бараа материалын зардал	-	4,818,440.00
210401	Бичиг хэрэг	-	1,369,250.00
210402	Тээвэр, шатахуун	-	1,327,430.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	2,121,760.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	840,000.00
210604	Урсгал засвар	-	840,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	544,000.00
210702	Дотоод албан томилолт	-	544,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	85,670,082.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	85,211,465.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	250,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	101,265.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	52,000.00
210807	Газрын төлбөр	-	55,352.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	51,434,324.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	5,109,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	1,869,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	-	44,455,224.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	5,111,415.74
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	2,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	2,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	3,111,415.74
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	3,111,415.74
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-	(5,971,024.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-	(5,971,024.00)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/
төгрөгөөр
/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	108,611,173.00	164,865,464.43	167,509,357.35	-	440,985,994.78
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(5,971,024.00)	-	(5,971,024.00)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	108,611,173.00	164,865,464.43	161,538,333.35	-	435,014,970.78

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	-	334,627,300.00

13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО	-	334,627,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	122,131,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	122,131,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	148,790,300.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	148,790,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	63,705,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	63,705,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	-	334,627,300.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	329,515,884.26
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	329,515,884.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	133,625,760.00
210101	Үндсэн цалин	-	115,163,667.00
210102	Нэмэгдэл	-	18,462,093.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	18,213,602.26
210201	Тэтгэврийн даатгал	-	13,338,137.58
210202	Тэтгэмжийн даатгал	-	1,237,791.47
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	970,152.90
210204	Ажилгүйдлийн даатгал	-	242,437.97
210205	Эрүүл мэндийн даатгал	-	2,425,082.34
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	62,205,300.00
210301	Гэрэл, цахилгаан	-	2,700,208.43
210302	Түлш, халаалт	-	57,785,300.00
210303	Цэвэр, бохир ус	-	1,719,791.57
2104	Хангамж, бараа материалын зардал	-	4,697,850.00
210401	Бичиг хэрэг	-	1,500,000.00
210402	Тээвэр, шатахуун	-	1,197,850.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	2,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	1,500,000.00
210604	Урсгал засвар	-	1,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	544,000.00
210702	Дотоод албан томилолт	-	544,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	102,756,472.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	102,297,855.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	250,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	101,265.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	52,000.00
210807	Газрын төлбөр	-	55,352.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	5,972,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	3,320,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	2,652,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	5,111,415.74
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	2,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	2,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	3,111,415.74
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	3,111,415.74

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТГ

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	0.00	289611700.00	286500284.26
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	0.00	289611700.00	286500284.26
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	0.00	289611700.00	284500284.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	0.00	137363100.00	133625760.00
210101	Үндсэн цалин	0.00	0.00	110303100.00	115163667.00
210102	Нэмэгдэл	0.00	0.00	27060000.00	18462093.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	0.00	18544000.00	18213602.26
210201	Тэтгэврийн даатгал	0.00	0.00	13049600.00	13338137.58
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	0.00	1373600.00	1237791.47

210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	0.00	1099100.00	970152.90
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	0.00	274500.00	242437.97
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	0.00	2747200.00	2425082.34
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	0.00	62205600.00	62205300.00
210301	Гэрэл, цахилгаан	0.00	0.00	2920300.00	2700208.43
210302	Түлш, халаалт	0.00	0.00	57785300.00	57785300.00
210303	Цэвэр, бохир ус	0.00	0.00	1500000.00	1719791.57
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	0.00	5150000.00	4697850.00
210401	Бичиг хэрэг	0.00	0.00	1630000.00	1500000.00
210402	Тээвэр, шатахуун	0.00	0.00	1350000.00	1197850.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	-	2,170,000.00	2,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	-	1,400,000.00	1,500,000.00
210604	Урсгал засвар	-	-	1,400,000.00	1,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	-	1,500,000.00	544,000.00
210702	Дотоод албан томилолт	-	-	1,500,000.00	544,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	-	58,838,700.00	58,545,872.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	-	58,296,700.00	58,087,255.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	-	250,000.00	250,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	-	150,000.00	101,265.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	-	52,000.00	52,000.00
210807	Газрын төлбөр	-	-	90,000.00	55,352.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	-	4,610,300.00	5,167,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	-	2,515,800.00	2,515,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	-	2,094,500.00	2,652,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	-	-	2,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	-	-	2,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	-	-	2,000,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	-	-	185,837,000.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	-	-	122,131,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	-	-	122,131,700.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	-	-	63,705,300.00
132001	Орон нутгийн төсвөөс	-	-	-	63,705,300.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

НТ-2

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	45,015,600.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	45,015,600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	45,015,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	44,210,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	44,210,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	805,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	805,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	45,015,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	45,015,600.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	45,015,600.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд санхүүгийн тайлан, бүртгэлд гарсан алдаа зөрчилтэй, холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аудитын газрын аудитор Б.Энхтөр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар нь “Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжил хамгааллын бодлогын хэрэгжилтийг хангаж, нийгмийн хамгааллын салбарын загвар үйлчилгээг бий болгоно” гэсэн эрхэм зорилгыг тавьж ажилласны хүрээнд гэр бүл, хүүхэд залуучуудтай ажиллах үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- ✓ Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг сайжруулж, салбар дундын хамтын ажиллагааг эрчимжүүлэх гэсэн зорилтуудыг хэрэгжүүлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар болон дотоод аудитын нэгжгүй боловч Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын даргын 2019 оны А/08 дугаар тушаалаар батлагдсан “Гэр бүл, хүүхэд, залуучуудын байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг үндэслэж 2021 онд байгууллагын үйл ажиллагаанд 7 удаа хяналт-шинжилгээ үнэлгээг хийхэд дотоод ажил, хугацаатай тайлан мэдээг бүртгэх, хоцроох, архив, хууль тогтоомжийн хэрэгжилтээс 11 зөрчил илэрснээр сүүлийн 3 удаагийн хяналт-шинжилгээ үнэлгээгээр ажил сайжирсан үзүүлэлттэй байгаа нь дотоод хяналт-шинжилгээ үнэлгээг үр дүнтэй хэрэгжүүлжээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 370.6 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 3.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 2.5 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар нь 2021 оны санхүүгийн тайлангийн тодруулгыг Сангийн сайдын 2006 оны 32 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тэмдэглэл бэлтгэх аргачлал” 2008 оны Сангийн сайдын “Тушаалд хэлтэст өөрчлөлт оруулах тухай” 252 дугаар тушаалыг баримталсан. Сангийн сайдын 388 дугаар журмын 3-р хавсралтын дагуу бэлтгэж тайлагнасан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/Мян.төг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Урьдчилж гарсан зардал			
Авлага	9535.0	3268.9	6266.1
Бараа материал	5688.7	19039.4	-13350.7
Үндсэн хөрөнгө	519797.7	551197.3	-31399.6
Нийт хөрөнгө	440985.9	435014.9	5971.02
Өглөг	0	0	0
Хуримтлагдсан үр дүн	167509.3	326403.7	-158894.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	440985.9	435014.9	5971.02

Авлага: Тайлант онд болон өмнөх оны хувь хүнээс авах авлага үүснээр эцсийн үлдэгдэл 3.3 сая төгрөгийн авлагатай байна.

Бараа материал: Оны эхний үлдэгдэл 5.6 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 19.03 сая төгрөг болж өмнөх оноос 13.3 сая төгрөгөөр буурсан байна. Тайлант онд 75.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж 62.08 сая төгрөгөөр хасагдуулсан байна.

Үндсэн хөрөнгө: Үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 519.8 сая, эцсийн үлдэгдэл 551.1 сая төгрөг болж өмнөх оноос 31.4 сая төгрөгөөр буурсан байна.

Тайлант онд үнэ төлбөргүй 31.4 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, тайлант онд шилжүүлсэн болон акталж данс бүртгэлээс хассан хөрөнгө байхгүй байна.

Өр төлбөр: Өглөгийн дансанд оны эхний болон эцсийн үлдэгдэлгүй байна.

Санхүү байдлын, орлого үр дүнгийн, мөнгөн гүйлгээний, өмчийн өөрчлөлтийн тайлангууд, санхүүгийн тодруулга тайлангуудын өөрчлөлт, нягтлан бодох бүртгэлийн зарчмыг

баримтлан, НБББ, санхүүгийн болон үйл ажиллагааны үр дүнгийн талаар болзошгүй өр төлбөр, авлагыг зэргийг тодруулж тайлагнасан болно.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар нь 2021 онд улсын төсвөөс 289.6 сая төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөсөн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар нь 2021 он улсын төсвөөс 289.6, нэмэлт дансаар 45.02 сая төгрөг буюу нийт 334.6 сая төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр 334.6 сая төгрөгийг зарцуулж 3.1 сая төгрөгийн хэмнэлттэй тайлагнажээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар нь 2021 онд нэмэлт дансаар нийт 45.02 сая төгрөгийн санхүүжилтээр залуучуудын хөгжлийн төвийн үйл ажиллагааг дэмжих 4.9, түр хамгаалах байрны зардалд 25.6, хамтарсан багт дэмжлэг үзүүлэх 5.0, хүчирхийлэл гэмт хэрэг зөрчлийн нөлөөллийн ажил хийх зардалд 9.5 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, хүүхэд хамгааллын тухай хуульд иргэн олон нийтэд хууль сурталчлах, хуулийн хэрэгжилтийг тайлагнах талаар тусгайлан заагдсан чиг үүрэг бий. Энэхүү чиг үүргийг хэрэгжүүлэх салбарын чиглэлээрх хийгдсэн ажлын тайланг олон нийтэд сурталчлах зорилгоор танилцуулга мэдээлэл бүхий гарын авлага, зурагт хуудсыг жил бүрийн сүүлийн улиралд хэвлүүлэн үр дүн ололт амжилтаа сурталчилдаг. 2021 оны байгууллагын тайлан мэдээлэл бүхий гарын авлагыг 1000 хувь хэвлүүлсэн байна. Мөн Сайхан Монгол телевизтэй хамтран ажиллах гэрээ байгуулж Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжил хамгааллын чиглэлээр төр засаг, орон нутгаас гарсан шийдвэрийг танилцуулах, хүүхэд өсвөр үеийнхэн, иргэн олон нийтэд сургалт нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах чиглэлээр хамтран гэрээ байгуулан ажиллажээ.

Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2021 оны санхүүгийн тайлангийн баталгаажуулалтаар тайлант онд хувь хүнээс авах 3.3 сая төгрөгийн авлагатай байна. Мөн шуудан холбооны зардлаас 0.2 сая төгрөгийн бичиг хэргийн материалыг зардал хооронд шилжүүлэн авсан байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус сумын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулж ажиллахдаа аудитын төлөвлөлтийн үе шатанд сонгосон нийт 9 эрсдэлийн хүрээнд горим сорилыг хэрэгжүүлэн ажиллалаа.

Дотоод хяналтын баг бүрэлдэхүүнийг тушаал шийдвэрээр томилоогүй боловч ажлын хэсэг гарган дотоод хяналт-шинжилгээ үнэлгээг 7 удаа хийсэн байна. Засгийн газрын 43 дугаар тогтоолыг мөрдөж ажилласан ажиллажээ. Бүлэг хоорондын зөвшөөрөлгүй шуудан холбооны зардлаас 0.2 сая төгрөгөөр бичиг хэргийн материал авсан нь Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тулаар, Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн 190 дүгээр тушаалын хавсралт "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг зөрчсөн байна. Хувь хүнээс авах 3.3 сая төгрөгийн авлагыг хүлээн зөвшөөрсөн байна. Илэрсэн алдаа зөрчилд холбогдох хууль журмын дагуу зөвлөмж өгч ажилласан.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй. Үүний дагуу байгууллагын мэдээллийг шилэн дансанд бүрэн мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэж байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар 3 зөвлөмж өгч ажилласнаас зөвлөмжийн хэрэгжилтийг тайланг 2021 оны 06 дугаар сарын 15-ний өдрийн 01/84 тоот албан бичгээр хүргүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Хувь хүнтэй холбоотой авлагыг барагдуулж анхан шатны баримтын бүртгэлийг хангаж ажиллах нь анхаарал татахуйц байна. Иймд 3.3 сая төгрөгийн авлагатай байгаа тул авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 3.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, санхүүгийн тайлантай холбоотой 1 залруулга, 3.4 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгч ажиллалаа.

4.1 Залруулсан алдаа

Орлого үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй гарсан зардал, үндсэн хөрөнгийн элэгдэл, үндсэн хөрөнгийн элэгдэл, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж, шуудан холбоо интернэтийн зардал үндсэн хөрөнгийн тайланд тооцоолол зэрэг бичилтийн алдааг залруулсан.

4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Авлагатай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тайлант онд хувь хүнээс авах 3.3 сая төгрөгийн авлагатай байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" заалтуудыг мөрдлөг болгож ажиллах.

2. Шуудан холбооны зардалтай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Шуудан холбооны зардлаас 194,640 төгрөгөөр бичиг хэргийн материал авсан байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн 190 дүгээр тушаалын хавсралт "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар" заалтыг баримталж ажиллах.

3. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Шилэн дансны мэдээллийг бүрэн мэдээлсэн байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 02 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/ д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчлийн дүн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар	3	3.4	1	0	0	0	0	0	2	3.4